

ҮНИЙН ХӨӨРӨГДӨЛД БОДЛОГООР НӨЛӨӨЛӨХ НЬ ШИНЭ ЗҮЙЛ

Зүүн өмнөд Азийн төвбанкуудын холбоо, Монголбанк хамтран хөрөнгийн үнийн өсөлт мөнгөний бодлогод хэрхэн нөлөөлөх тухай гурван өдөр хэлэлцсэн юм. Солонгос, Тайланд, Япон зэрэг 12 орны 30 орчим төлөөлөгч оролцож, номын дуу сонслоо. Хөрөнгийн үнийн инфляц ба үнийн хөөрөгдөл, хямралаас үлдсэн сургамж, олон улсын туршлага зэрэг манай орны хувьд шинэхэн сэдвийг хамарсан. Сургалтын үеэр Монголбанкны Мөнгөний бодлогын газрын эдийн засагч Д.Батнямтай ярилцлаа.

-Хөрөнгийн үнийн хөөрөгдөл гэж юуг хэлээд байна вэ?

-Үнэ гэдгийг эдийн засгийн тодорхой хүчин зүйлсээр тайлбарлах ёстой. Гэтэл тайлбарлагдаж байгаа зүйл маань эдийн засгийн хүчин зүйлээсээ илүү давсан үнийн хэт өсөлт хөөсрөлт бий болгодог. Энэ нь тодорхой учир шалтгаантай. Зарим хүн ашиг олох сонирхлоор хэт хиймлээр үнийг өсгөх ч юм уу, эсвэл эдийн засагт байгаа эрэлтээс давсан нийлүүлэлт бий болгосноос шалтгаалдаг. Үнэ өсч, ямар нэгэн байдлаар халалт бий болсон тохиолдолд санхүү, банкны зах зээлд хор хохирол учруулдаг. Хөрөнгийн үнэ гэдэгт манай зах зээл дээр орон сууцны үнийг хэлж болно. Орон сууцны үнэ хэт өссөнөө эргээд гэнэт буурахад банкуудын барьцаанд байгаа орон сууцны үнэлэмж нь буурчихна. Тиймээс банкинд алдагдалтай болно. Эсвэл хөрөнгийн зах зээл дээр хувьцааны үнэ хэт өсч байгаад гэнэт огцом буурсан тохиолдолд хөрөнгөө оруулсан хүмүүс алдагдалд орж эхэлдэг.

-Энэхүү хөрөнгийн үнийн өсөлтийг яаж хэмждэг юм бэ?

-Ерөнхийдөө хэмжих үндсэн стандартууд байгаа. Зарим орны хувьд хэрэглээний үнийн индекс оруулдаг. Зарим орон тусгай индекс гарган хэмждэг. Манай орны хувьд 2008 оноос Үндэсний статистикийн хорооноос улирал бүр орон сууцны үнийн индексийг тооцож эхэлсэн. Хөрөнгийн зах зээлийн хувьд тодорхой. Хувьцаануудын дундажчилсан үнэ гэж байгаа. Манай улсынхаар бол ТОП-20 индекс. Үүгээр бид хөрөнгийн үнийг хэмжиж болно гэсэн үг.

-Иймэрхүү үнийн хөөрөгдөлд бодлогын хариуг яаж үзүүлдэг вэ?

-Тодорхой стандарт хариу үйлдлүүд байдаг ч энэ нь манай улсын хувьд шинэ зүйл. Гэвч дэлхийн эдийн засгийн хямрал Монгол Улсын хувьд нөлөө үзүүлэхүйц байсан. Гадаадын улс орнууд энэхүү хямралтай хэрхэн тэмцсэн, өмнө нь болсон хямралтай хэрхэн тэмцэж байсан туршлагыг бид хуваалцаж байна. Тиймээс бид үүнд үндэслээд Монголд ч гэсэн цаашид иймэрхүү эдийн засгийн хямрал бий болгохгүйн тулд юу хийх вэ гэдэг нь чухал.

-Хямралын эсрэг Монголбанкны хэрэгжүүлсэн бодлогын үр дүн хэзээ гарч эхлэх бол?

-Манай улсад анх 2007 оноос эхэлж эдийн засгийн хэт халалт бий боллоо гэдгийг тодорхойлсон. Энэхүү хэт халалт нь хөрөнгийн үнийн өсөлтийг хойноосоо дагуулж, хоорондоо хүчтэй хамааралтай үзэгдлүүд болсон юм. Бид энэхүү хэт халалтыг зогсоох, сэргийлэх бодлогын арга хэмжээг авч эхэлсэн. Энэхүү мөнгөний бодлого маань өнгөрсөн оны I улирал хүртэл үргэлжилсэн. Үүний дараа бид эдийн засгаа дэмжихийг хичээсэн. Инфляц харьцангуй намсч ирсэн. Санхүүгийн салбарт эхний хоёр банк хямралд орсон ч банкны систем

эргээд харьцангуй тогтвортой болж эхэлсэн. Зээлийн уналт тогтворжсон. Мөнгөний агрегат буцаад өсөх хандлага ажиглагдсан гэх мэт хүчин зүйлүүд эргээд мөнгөний бодлогоо зөөлрүүлэх эхлэлийг өнгөрсөн оны II улирлаас тавьсан байгаа. Төвбанкны авч хэрэгжүүлсэн бодлогын нөлөө яаж илэрч байна вэ гэдэг нь эдийн засаг, банкны салбарын үзүүлэлтүүд яаж сэргэж байна, одоо ямар байна вэ гэдгээр илэрхийлэгдэнэ.

-Тэгвэл манай улсын хувьд макро, микро эдийн засгийн үзүүлэлтүүдийн харьцааг та юу гэж үзэж байна вэ. Ямар байх ёстой юм бэ?

-Яг ямар байх ёстой вэ гэдгийг тодорхой хэлэхэд жаахан хүнд. Яагаад гэвэл, бид кредит тавиад, ийм байх ёстой гээд нэг дүн тавьчихвал ямар нэгэн дүрэм гаргах болно. Ингээд чанга дүрэм гаргачихвал эргээд үүндээ хэт баригдсанаас санхүүгийн хямрал ч юм уу, эсвэл тодорхой бус байдлыг бий болгох үр дагавартай. Тиймээс харьцангуй уян хатан байж, эдийн засгийн тодорхой нөхцөлд ирээдүйгээ харсан байдлаар бид бодлогоо хэрэгжүүлдэг. Тиймээс бид хатуу хязгаартай, ийм тийм байх ёстой гэдэг кредит тавьж түүнийгээ нийтэд зарлах нь эдийн засаг эсрэг үйл хөдлөл.

Г.ГАНЧИМЭГ
